



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВ

Хөдөлмөрийн ордон, Чингисийн өргөн чөлөө, 2 дугаар
хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас: 70124949, Факс: 70124949
Цахим шуудан: info@osh.gov.mn
Цахим хуудас: www.osh.gov.mn

2025.07.09 № 01/334

танай _____-ны № _____-т

Хөдөлмөрийн нөхцөлийн
үнэлгээний тайлан хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн хүсэлтийн дагуу Х/25/21 тоот ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд 45 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийж, тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд үндэслэн гаргасан заавар, зөвлөмж, цаашид авах арга хэмжээний саналыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Үнэлгээний зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг, тайлангийн хамт 2026 оны 07 дугаар сарын 09-ний дотор хэвэлмэл болон цахим [/prevention@osh.mn/](mailto:prevention@osh.mn) хаягаар албан бичгийн хамт ирүүлнэ үү.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
Удирдлага
Дарга
Дамиран Нарансүх
2025-07-09 12:07:28



АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ АХУЙН
ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ



АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: БАЙГАЛЬ, ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

ТАЙЛАНГИЙН ДУГААР: OSH 2506/2521

Хэвлэсэн огноо: 2025.07.09

Улаанбаатар хот
2025 он



АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ АХУЙН
ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ



Байгаль, орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан

Тайлангийн дугаар: OSH 2506/2521

1. Байгууллагын мэдээлэл

Захиалагч байгууллага

Байгаль, орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
яам

Хаяг: Барилгачдын талбай, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас (976) 99101493

Цахим хуудас:

Цахим шуудан: contact@mecc.gov.mn

Гүйцэтгэгч байгууллага

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн
төв

Хаяг: Хөдөлмөрийн ордон, Хан-Уул дүүрэг,
2-р хороо, Улаанбаатар, Монгол улс

Утас (976) 70124949

Цахим хуудас: www.osh.gov.mn

Цахим шуудан: info@osh.gov.mn



АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ АХУЙН
ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ



**Байгаль, орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний
тайлан**

Тайлангийн дугаар: OSH 2506/2521

3. Тайлан боловсруулан баталгаажуулсан

Үндэсний итгэмжлэлийн төвөөс MNS ISO/IEC 17020 стандартаар итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллага үнэлгээг ХНХС-ын А/155 дугаар тушаал "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-ын дагуу, MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг ашиглан хийж гүйцэтгэв.

Зөвшөөрсөн

Д.Нарансүх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга, Мэргэшсэн хөдөлмөрийн эрүүл ахуйч

/гарын үсэг/



Хянаж баталгаажуулсан

М.Сэлэнгэ, Хөдөлмөрийн нөхцөл хариуцсан ахлах мэргэжилтэн

/гарын үсэг/

Тайлан боловсруулсан

Т.Замбага, Хөдөлмөрийн эрүүл ахуйч



/гарын үсэг/

4. Албан хүсэлт

Зөвлөмжийн дагуу хөдөлмөрийн нөхцөл сайжруулсан тайланг имэйлээр болон шуудангаар ирүүлнэ.

5. Үнэлгээний сэтгэл ханамж болон санал хүсэлтээ дараах QR код болон линкээр ирүүлнэ үү.

Хөндлөнгийн хяналтын төлөвлөгөө, явц, тайлан болон бусад санал хүсэлт



НЭГ. ЕРӨНХИЙ

1.1 Удиртгал

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндэд нь дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байр, үйлдвэрлэлийн орчны хими, физик, сэтгэлзүй, физиологи, биологийн хортой хүчин зүйлсийн өртөлтийг хэмжин тодорхойлж, үр дүнг хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулан дүгнэж, эрсдэлийг үнэлж, ажилтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг төлөвлөх нотолгоог бий болгох нэгдмэл үйл ажиллагаа болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн эрүүл ахуй, хөдөлмөрийн анагаах ухаан, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжлийн, сургалтын, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг Монгол Улсын хэмжээнд зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажиллах чиг үүрэг бүхий Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалтыг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон харьяа байгууллагуудын ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2025 оны 06 дугаар сарын 2-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд хийв.

Энэхүү үнэлгээг хийхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам, MNS 5080:2023, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага стандартыг мөрдөж ажиллав.

1.2 Зорилго

Байгаль, орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон харьяа байгууллагуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг MNS 5080:2023 стандартын дагуу үнэлж, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах.

1.3. Үнэлгээ хийсэн хугацаа

Энэхүү ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 08-ны хооронд дараах үе шатаар хэрэгжүүлэв.

Хүснэгт 1. Үнэлгээний үе шат

1. Хүсэлт хүлээн авах	2025.04.30
2. Төлөвлөх	
✓ Ажлын байрны мэдээлэл цуглуулах ✓ Гэрээ байгуулах ✓ Төлөвлөгөө гаргах ✓ Багаж хэрэгслийг бэлдэх	2025.05.16
3. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг явуулах	
✓ Нээлтийн хурал хийх ✓ Хэмжилт хийх, сорьц цуглуулах ✓ Хаалтын хурал хийх	2025.06.02-06.13
4. Лабораторийн шинжилгээ	
✓ Цуглуулсан сорьцод шинжилгээ хийх	2025.06.16-06.20
5. Хэмжилт шинжилгээний үр дүн боловсруулах	
✓ Дескриптив статистик үзүүлэлтийг ажлын байрны бүлэг бүрээр тооцох	2025.06.23-06.27
6. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулах	
✓ Эрүүл мэндийн эрсдэлийн түвшинг үнэлэх ✓ Хөдөлмөрийн нөхцөлийг ангилах	2025.06.27-07.04
7. Тайлан боловсруулах, хүлээлгэн өгөх	2025.07.08

1.4 Үнэлгээнд хамрагдсан байгууллага, албан тушаалын мэдээлэл

Хүснэгт 2. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын мэдээлэл

Байгууллагын нэр, регистрын дугаар	Эдийн засгийн үйл ажиллагаа		Нийт албан тушаалын тоо	Нийт ажилтны тоо
	Салбар	Дэд салбар /код/		
Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам 9085084	Экологийн тэнцлийг хангах, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх	-	Яам-122 Усны газар-38 Ойн газар- 38	-
Хаяг, харилцах утас	15141 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3 Засгийн газрын 12 дугаар байрны 4 дүгээр давхарт contact@mecc.gov.mn/			
Үнэлгээнд хамрагдсан ажлын байрны байршил	- Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3 Засгийн газрын 12 дугаар байрны 4 дүгээр давхарт - Чингэлтэй дүүрэг, 4-р хороо ЦУОШГазар - Хан-Уул дүүрэг, 20-р хороо Чингисийн өргөн чөлөө, БОЛаборатори - Баянгол дүүрэг, 6-р хороо Кёкүшү цамхаг 3 давхарт - Баянгол дүүрэг, 2-р хороо Усны газрын байр - Төв аймаг Эрдэнэ сум, Мөнгөнморьт сум, Батсүмбэр сум - Сэлэнгэ аймаг Мандал сум			
Үнэлгээнд байлцсан албан тушаалтан, харилцах мэдээлэл	БОУАӨЯам-ны Хяналт, дотоод аудитын хэлтсийн дарга Буяннэмэх, 99101493			

Хүснэгт 3. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан албан тушаалын мэдээлэл

Д/д	Албан тушаал	Ажилт ны тоо	Ижил өртөлти йн бүлэг	Өдөр тутмын ажлын цаг	7 хоногийн ажлын дундаж цаг	Түүвр ийн тоо	Өмнөх ХНУ- ний үр дүн	ХН-ийг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх
1	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагнал хариуцсан АМ	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
2	Хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
3	Салбар дундын зохицуулалт, түншлэл, ХАХАМ	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
4	Хүний нөөцийн мэргэжилтэн	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
5	Өргөдөл, гомдол, жендер, гамшиг, дайчилгаа хариуцсан АМ	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
6	Хэвлэл мэдээллийн ажилтан	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
7	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны АМ	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
8	Нярав	1	ИӨБ-1	8	40	6	Хийлгэж байгаагүй	-
9	Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан хариуцсан АМ	1	ИӨБ-2	8	40	5	Хийлгэж байгаагүй	-
10	БОМС-ийн зураглал, бүртгэл хариуцсан АМ	1	ИӨБ-2	8	40	5	Хийлгэж байгаагүй	-
11	Тусгай хамгаалттай газрын зураглал, бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1	ИӨБ-2	8	40	5	Хийлгэж байгаагүй	-
12	Тогтвортой, санхүүжилт, түншлэл,	1	ИӨБ-2	8	40	5	Хийлгэж байгаагүй	-

	хамтын ажиллагаа ХМ							
13	Экологийн боловсрол хаируцсан мэргэжилтэн	1	ИӨБ-2	8	40	5	Хийлгэж байгаагүй	-
14	Нуурын усны чанар, хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
15	Гол мөрний усны чанар, хяналт шинжилгээ хариуцсан инженер	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
16	Байгаль орчны чанарын асуудал хаиуцсан шинжээч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
17	Агаарын чанарын хяналт шинжилгээ хариуцсан шинжээч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
18	Хөрсний чанарын хяналт шинжилгээ хариуцсан ахлах шинжээч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
19	Цацрагын чанарын хяналт шинжилгээ хариуцсан шинжээч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
20	Агаарын даралтын хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
21	Чийг температур хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
22	Хүний нөөц, химийн бодисын бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
23	Захиргаа, удирдлагын хууль эрхзүйн АХАМ	1	ИӨБ-3	8	40	2	Хийлгэж байгаагүй	-
24	ЗУХ-н архив бичиг хэргийн эрхлэгч	1	ИӨБ-3	8	40	2	Хийлгэж байгаагүй	-
25	Ойн НСХ-н мод үржүүлгийн газар, тарьц, суулгацын нөөцийн АХАМ	1	ИӨБ-4	8	40	2	Хийлгэж байгаагүй	-
26	Ойн НСХ-н үрийн нөөцийн АХМ	1	ИӨБ-4	8	40	2	Хийлгэж байгаагүй	-
27	Ойн НСХ-н ойн баялаг ашиглалт ХАМ	1	ИӨБ-5	8	40	2	Хийлгэж байгаагүй	-
28	Ойн НСХ-н ойн анги, мэргэжлийн байгууллага, нөхөрлөл ХМ	1	ИӨБ-5	8	40	2	Хийлгэж байгаагүй	-
29	Ахлах нягтлан бодогч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
30	Хаягдал усны асуудал хариуцсан АМ	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
31	Үйлдвэр үйлчилгээний салбарын ус ашиглалт ХМ	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
32	Усны хайгуул судалгаа ХМ	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
33	Усны хэмнэлт, инноваци хариуцсан мэргэжилтэн	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-

34	Байгаль хамгааллын байцаагч (Эрдэнэ сум)	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
35	Байгаль хамгааллын байцаагч (Мөнгөнморьт сум)	1	-	8	400	1	Хийлгэж байгаагүй	-
36	Байгаль хамгаалагч (Мөнгөнморьт сум) Хан Хэнтийн ТХГН	6	-	14/14	336/40дээш	2	Хийлгэж байгаагүй	-
37	Байгаль хамгаалагч (Батсүмбэр сум)	6	-	14/14	336/40	1	Хийлгэж байгаагүй	-
38	Байгаль хамгаалагч (Мандал сум)	6	-	14/14	336/40	1	Хийлгэж байгаагүй	-
39	Сум дундын ойн ангийн дарга	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
40	Ахлах мэргэжилтэн	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
41	Мэргэжилтэн	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
42	Нягтлан бодогч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
43	Жолооч техникч	1	-	8	40	1	Хийлгэж байгаагүй	-
44	Усны харуул	2	-	8-12	365	2	Хийлгэж байгаагүй	-
45	Цаг уурч	4	-	24/8/	48/40	4	Хийлгэж байгаагүй	-

ХОЁР. АРГАЧЛАЛ

Энэхүү ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийхэд MNS 5080:2023 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага стандартаар тогтоосон аргачлалыг мөрдөж ажиллав.

Стандарт заасан шаардлагын дагуу ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг дараах үе шатуудаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн урьдчилсан мэдээллийг цуглуулалт
- 2) Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний төлөвлөгөө боловсруулалт
- 3) Ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, сорьц цуглуулалт
- 4) Хэмжилтийн үр дүнгийн боловсруулалт, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ
- 5) Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, тайлан, зөвлөмж боловсруулалт
- 6) Үнэлгээний үр дүнг тайлагнах, хүлээлгэн өгөх.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн урьдчилсан мэдээллийг цуглуулах шатанд Энэ нь үнэлгээний үе шат бөгөөд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдах ажлын байрны сөрөг хүчин зүйлсийн хэмжилтийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгч байгууллагаас авав.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний төлөвлөгөө боловсруулахад өмнөх үе шатанд цуглуулсан мэдээллийг ашиглан үнэлгээнд хамрагдах ажлын байр бүр дэх ажилтны эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүх хүчин зүйлсийн өртөлтийг тодорхойлох хэмжилт, үнэлгээг төлөвлөв.

Үнэлгээнд хамрагдсан албан тушаалуудыг MNS 5080:2023 стандартын дагуу ижил өртөлтийн бүлгээр нь ангилж, хэмжилт, сорьц цуглуулалтын түүврийн тоог статистикийн хувьд хүчин төгөлдөр төлөөлөхөөр тооцов.(Хүснэгт 3).

Ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, сорьц цуглуулах болон лабораторийн шинжилгээ хийлгэхэд Хүснэгт 4-д заасан стандарт аргуудыг ашиглав.

Хүснэгт 4. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хэмжилт, сорьц цуглуулалт, шинжилгээнд ашигласан стандарт арга

Үзүүлэлт (ажлын байрны хүчин зүйл)	Стандарт арга	Хэмжилтийн аргачлал	Хэмжилтийн хугацаа
Бичил цаг уур (агаарын температур, харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөний хурд)	MNS 6999:2023	Талбайн хэмжилт	5 минутын дундаж
Гэрэлтүүлэг	MNS 6767:2019	Талбайн хэмжилт	5 минутын дундаж
Шуугианы өртөлт	MNS 6768:2019	Талбайн хэмжилт	5 минутын дундаж
Цулцанд нэвтэрдэг тоос, мг/м ³	MNS 4990:2023	Хувь хүнд зүүх	120 минутын дундаж
Аммиак	MNS 4990:2023	Талбайн хэмжилт	5 минутын дундаж
Ажилтай холбоотой ядралт	MNS 5080:2023	Асуумж, ярилцлага	-
Эргономик	REBA, RULA	Ажиглалт, асуумж	-

Хэмжилтийн үр дүнгийн боловсруулалт хийхэд ажлын байрны бүлэгт бүрд хийсэн хэмжилт, үнэлгээ болон цуглуулсан сорьцод хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнд дескриптив статистик боловсруулалтыг MNS 5080:2023 стандартын дагуу хийж, дараах утгуудыг тодорхойлов. Үүнд:

- Хамгийн бага болон их утга
- Арифметик дундаж, 90 хувийн итгэх дээд хязгаар

- Голч утга
- Геометр дундаж, 90 хувийн итгэх дээд хязгаар
- Стандарт хазайлт
- Статистик тархалт

Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийхэд MNS 5080:2023 стандартад хийсэн шаардлагыг мөрдлөг болгож хэмжилтийн үр дүнгийн дундаж утгын 90 хувийн итгэх дээд хязгаарын утгыг 8 болон 12 цагт жинлэсэн дундаж өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ)-ний ач холбогдол бүхий утгатай харьцуулан, ажилтны эрүүл мэндийн эрсдэлийн түвшнийг тодорхойлов. Өдөрт 8-12 цагаас илүү цагаар ажилладаг ажилтнуудын өртөлтийг харьцуулан үнэлэх ЗДХ-г стандартын дагуу тооцож тодорхойлов.

Хүснэгт 5. Өртөлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, сэрэмжлэх түвшин

Үзүүлэлт (ажлын байрны хүчин зүйл)	Стандарт	8 ЦЖД өртөлтийн ЗДХ	Сэрэмжлэх түвшин	12 ЦЖД өртөлтийн ЗДХ	Сэрэмжлэх түвшин
Температур, °C	MNS 6999-2023	17-26	-	17-26	-
		22-28	-	22-28	-
Харьцангуй чийглэг, %	MNS 6999-2023	30-60	-	30-60	-
Агаарын урсгалын хурд, м/с	MNS 6999-2023	0.3≤	-	0.3≤	-
Гэрэлтүүлэг, люкс	MNS 6767:2019	500	-	500	-
		300	-	300	-
Шуугиан, дБА	MNS 6768:2019	85	80	83	80
Цулцанд нэвтэрдэг тоос, мг/м ³	MNS 4990:2023	2	1	1.33	0.6
Аммиак	MNS 4990:2023	17 24.3 Богино хугацааны өртөлт	8.5	-	-

Албан тушаал бүрийн ажлын байранд тодорхойлогдсон сөрөг хүчин зүйлийн өртөлтөөс ажилтны эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн түвшинд үндэслэн MNS 5080:2023 стандартын дагуу **ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангиллыг** хийв.

Хүснэгт 6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал (MNS 5080:2023)

Хөдөлмөрийн нөхцөл	Эрүүл мэндийн эрсдэлийн түвшин	Тодорхойлолт
Хэвийн	Эрсдэлгүй	Ажилтан өдөр тутам ажлын байрныхаа хүчин зүйлсэд өртөж ажиллахад урт хугацаанд амь нас, эрүүл мэнд, амьдралын чанар, хөдөлмөрийн чадварт нь сөргөөр нөлөөлөхгүй байх ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл
	Дунд	Ажилтан өдөр тутам ажлын байрны хүчин зүйлсэд өртөж ажиллахад урт хугацаанд эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөхгүй ч ажлын бүтээмжийг бууруулах, тааламжгүй нөлөө үзүүлэх ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл
Хэвийн бус	Өндөр	Ажилтан өдөр тутам ажлын байрны хүчин зүйлсэд өртөж ажиллахад урт хугацаанд эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх, хөдөлмөрийн чадварыг нь бүр мөсөн алдагдуулах, амьдралын чанарыг нь бууруулах сөрөг үр дагавартай эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл
	Ноцтой	Ажилтан өдөр тутам ажлын байрны хүчин зүйлсэд өртөж ажиллахад урт хугацаанд эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх, (цэрэг, цагдаагийн албан хаагчид) ажил үүргээ гүйцэтгэх явцад бусдын халдлагад өртөх зэргээр хөдөлмөрийн чадварыг нь бүр мөсөн алдагдуулах, амьдралын чанарыг нь бууруулах сөрөг үр дагавартай, богино хугацаанд хурц хордлого үүсгэх зэргээр амь насанд нь аюултай эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнд нөлөө үзүүлэх орчны болон бусад хүчин зүйлсийг тооцон оруулав.

Хүснэгт 7. Үнэлгээ хийх үеийн цаг агаарын байдал, ажлын ачаалал, бусад нөлөөлөх хүчин зүйл

№	Ажлын байрны нэр	Ажлын ачаалал	Ажлын ээлж	Улирлын чанартай ажил	Цаг агаарын байдал
1	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагнал хариуцсан АМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
2	Хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
3	Салбар дундын зохицуулалт, түншлэл, ХАХАМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
4	Хүний нөөцийн мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
5	Өргөдөл, гомдол, жендер, гамшиг, дайчилгаа хариуцсан АМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
6	Хэвлэл мэдээллийн ажилтан	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
7	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны АМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
8	Нярав	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
9	Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан хариуцсан АМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
10	БОМС-ийн зураглал, бүртгэл хариуцсан АМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
11	Тусгай хамгаалтын газрын зураглал, бүртгэл хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
12	Тогтвортой, санхүүжилт, түншлэл, хамтын ажиллагаа ХМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
13	Экологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
14	Нуурын усны чанар, хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
15	Гол мөрний усны чанар, хяналт шинжилгээ хариуцсан инженер	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
16	Байгаль орчны чанарын асуудал хариуцсан ахлах шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
17	Агаарын чанарын хяналт шинжилгээ хариуцсан шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
18	Хөрсний чанарын хяналт шинжилгээ хариуцсан ахлах шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
19	Цацрагийн чанарын хяналт шинжилгээ хариуцсан шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
20	Агаарын даралтын хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
21	Чийг температур хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
22	Хүний нөөц, химийн бодисын бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	21°C багавтар үүлтэй
23	Захиргаа, удирдлагын хууль эрхзүйн АХАМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
24	ЗУХ-н архив бичиг хэргийн эрхлэгч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй

25	Ойн НСХ-н мод үржүүлгийн газар, тарьц, суулгацын нөөцийн АХАМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
26	Ойн НСХ-н үрийн нөөцийн АХМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
27	Ойн НСХ-н ойн баялаг ашиглалт ХАМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
28	Ойн НСХ-н ойн анги, мэргэжлийн байгууллага, нөхөрлөл ХМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
29	Ахлах нягтлан бодогч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
30	Хаягдал усны асуудал хариуцсан АМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
31	Үйлдвэр үйлчилгээний салбарын ус ашиглалт ХМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
32	Усны хайгуул судалгаа ХМ	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
33	Усны хэмнэлт, инновац хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	16°C бага зэрэг салхитай, үүлтэй
34	Байгаль хамгааллын байцаагч (Эрдэнэ сум)	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
35	Байгаль хамгааллын байцаагч (Мөнгөнморьт сум)	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
36	Байгаль хамгаалагч (Мөнгөнморьт сум) Хан Хэнтийн ТХГН	Хүнд	14 хоног постон дээрээ 24 цаг 14 хоног 8 цагаар ажилладаг	Үгүй	28°C халуун бүгчим
37	Байгаль хамгаалагч (Батсүмбэр сум)	Хүнд	14 хоног постон дээрээ 24 цаг 14 хоног 8 цагаар ажилладаг	Үгүй	27°C
38	Байгаль хамгаалагч (Мандал сум)	Хүнд	14 хоног постон дээрээ 24 цаг 14 хоног 8 цагаар ажилладаг	Үгүй	27°C
39	Сум дундын ойн ангийн дарга	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
40	Ахлах мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
41	Мэргэжилтэн	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
42	Нягтлан бодогч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
43	Жолооч техникч	Хэвийн	Өдрөөр	Үгүй	24°C
44	Усны харуул	Хүнд	Жилийн 365 хоног цаг тогтмол бус	Үгүй	24°C
45	Цаг уурч	Хэвийн	Өдрөөр ээлжээр /	Үгүй	24°C

Хүснэгт 8. *- Ажлын ачааллын онцлог

Албан тушаал	Ажлын ачаалал их үед	Ажлын ачаалал бага үед	Ажлын онцлог, ач холбогдол
Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагнал хариуцсан АМ	Засгийн газар болон яамнаас гарсан тогтооллын хэрэгжилтийг хянаж, тайланг нэгтгэдэг		
Хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч	Хүний нөөцийн асуудал хариуцна		
Салбар дундын зохицуулалт, түншлэл, ХАХАМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Хүний нөөцийн мэргэжилтэн	Хүний нөөцийн асуудал хариуцна		
Өргөдөл, гомдол, жөндөр, гамшиг, дайчилгаа хариуцсан АМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Хэвлэл мэдээллийн ажилтан	Хэвлэл, мэдээллийн асуудал хариуцна		
Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны АМ			
Нярав	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан хариуцсан АМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
БОМС-ийн зураглал, бүртгэл хариуцсан АМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Тусгай хамгаалттай газрын зураглал, бүртгэл хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Тогтвортой, санхүүжилт, түншлэл, хамтын ажиллагаа ХМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Экологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Нуурын усны чанар, хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Улсын хэмжээний 590 орчим усны харуулаас ирсэн нуурын дээжийнд шинжилгээ хийж 4-10 сар хүртэл ирнэ.	Хүйтний улиралд судалгааны ажил хийнэ.	Лабораторид шинжилгээ хийнэ
Гол мөрний усны чанар, хяналт шинжилгээ хариуцсан инженер	Улсын хэмжээний 590 орчим усны харуулаас ирсэн нуурын дээжийнд шинжилгээ хийж 4-10 сар хүртэл ирнэ.	Хүйтний улиралд судалгааны ажил хийнэ.	Лабораторид шинжилгээ хийнэ
Байгаль орчны чанарын асуудал хариуцсан ахлах шинжээч	Улаанбаатар хотын агаарын чанарын асуудал хариуцна		
Агаарын чанарын хяналт шинжилгээ хариуцсан шинжээч	Улаанбаатар хотын агаарын чанарын асуудал хариуцна		
Хөрсний чанарын хяналт шинжилгээ хариуцсан ахлах шинжээч	Улсын хэмжээний хөрсний дээжид шинжилгээ ачаалал харилцан адилгүй		
Цацрагийн чанарын хяналт шинжилгээ хариуцсан шинжээч	Улсын хэмжээний хөрсний дээжид цацрагийн шинжилгээ хийнэ		
Агаарын даралтын хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч	Улсын хэмжээний бүх хүсэлт гаргасан агаарын даралт хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хийнэ		
Чийг температур хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт хариуцсан ахлах шинжээч	Улсын хэмжээний бүх хүсэлт гаргасан чийглэг, температур хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хийнэ		
Хүний нөөц, химийн бодисын бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн	Зөвшөөрөлтэй 90 гаруй нэр төрлийн бодисны бүртгэл		
Захиргаа, удирдлагын хууль эрхзүйн АХАМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
ЗУХ-н архив бичиг хэргийн эрхлэгч	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Ойн НСХ-н мод үржүүлгийн газар, тарьц, суулгачын нөөцийн АХАМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Ойн НСХ-н үрийн нөөцийн АХМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Ойн НСХ-н ойн баялаг ашиглалт ХАМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Ойн НСХ-н ойн анги, мэргэжлийн байгууллага, нөхөрлөл ХМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Ахлах нягтлан бодогч	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Хаягдал усны асуудал хариуцсан АМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Үйлдвэр үйлчилгээний салбарын ус ашиглалт ХМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн

Усны хайгуул судалгаа ХМ	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Усны хэмнэлт, инноваци хариуцсан мэргэжилтэн	Хэвийн	Хэвийн	Хэвийн
Байгаль хамгааллын улсын байцаагч (Эрдэнэ сум, Мөнгөнморьт сум)	Байгаль хамгаалалын хяналтын үйл ажиллагаа эрхэлнэ.		
Байгаль хамгаалагч (Мөнгөнморьт, Батсүмбэр, Мандал сум) Хан Хэнтийн ТХГН	14 хоног 24 цагаар 1-2 лаа постон дээрээ байрлана . Ойн цэвэрлэгээний зөвшөөрөлтэй газруудын цэвэрлэгээ ний үйл явцад хяналт тавина Хулгайн антай тэмцэнэ	Ой хаасан 3 сард ачаалал багасдаг Харилцаа холбооны сүлжээ байхгүй, муу Бие хамгаалах хэрэгсэл дутмаг Баавгай, чоно ихтэй	Жилд 2-3 удаа мориор 7-14 орчим хоног нийт хамгааллын бүсээрээ гүний эргүүл хийнэ. Хулгайн антай тэмцэнэ
Сум дундын ойн ангийн дарга	Төв аймгийн 6 сумын ойг хамардаг	03/15-6/14 ой хаадаг ачаалал багасна	Ойн цэвэрлэгээний хэм хэмжээг гаргаж, цэвэрлэгээ хийх байгууллагын үйл ажиллагааг хянан,
Ахлах мэргэжилтэн	- Сардаа 1-2 удаа сумдаар явдаг		
Мэргэжилтэн	- 11/15-03/15 ойн цэвэрлэгээ ачааллын үе - 06/15-09/15 ой нээх үе		
Нягтлан бодогч	Хэвийн		
Жолооч техникч	Ангийн үйл ажиллагааны төлөвлөөгөөний дагуу ажлуудад машин барьж явна		
Усны харуул	Хэвийн үед өдөрт 4 удаа мэдээ явуулдаг голын урсгалын хурд, түвшний хэмжээ	Голын түвшин ихэссэн аюултай үед 2 цагийн зайтай тогтмол мэдээ явуулдаг	Голын урсгалын хурд болон голын түвшинг өөрөө гол дотор орж тогтоосон цэгүүд дээр хэмждэг ба өвөл цооног гаргаж хэмждэг
Цаг уурч	Цаг агаарын байдал, салхины чиглэл, ургацын байдал зэргийг мэдээллэдэг		

ГУРАВ. ҮР ДҮН

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний хүрээнд 43 ажлын байрыг хамруулж, ажлын байр бүрээс хэмжилтэд хамрагдах төлөөллийн тоо (түүврийн тоо 45)-г захиалагч байгууллагатай зөвшилцөн тодорхойлсон гэрээний дагуу хэмжилтийг хийв.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааруулан цулцанд нэвтэрдэг тоос, шуугиан, гэрэлтүүлэг, бичил цаг уурын хэмжилтүүд, эргономик болон ажилтай холбоотой ядралтын зэргийг асуумж судалгаагаар үнэлсэн. Үүнд:

- Бичил цаг уур (агаарын температур, харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөний хурд)-ын хэмжилтийг дээрх ажлын байруудад хийж гүйцэтгэхэд бүх ажлын байранд агаарын урсгалын хурд, ИӨБ 1, 2, 4, 5, 7, Байгаль орчны лабораторийн бүх шинжээч нар, хүний нөөц химийн бодисын бүртгэл хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгааллын улсын байцаагч, ойн газрын мэргэжилтнүүд, усны газрын мэргэжилтнүүд нарын ажлын байранд агаарын харьцангуй чийглэг хангалтгүй үнэлэгдсэн.
- Физикийн хүчин зүйл буюу гэрэлтүүлэг, шуугиан хэмжилт хийсэн Байгалийн нөөцийн газрын мэргэжилтнүүд, гидробиологийн лаборатори, Байгаль орчны лаборатори, ойн НСХ ойн анги мэргэжлийн байгууллага нөхөрлөл хариуцсан мэргэжилтэн, хаягдал ус хариуцсан мэргэжилтэн, үйлдвэр үйлчилгээний салбарын ус хариуцсан мэргэжилтэн, сум дундын ойн анги, Мөнгөнморьт сумын цаг уурын газрын ажлын байранд зөвшөөрөгдөх хэмжээнд хүрэхгүй гэж үнэлэгдсэн.
- Химийн хүчин зүйл буюу цулцанд нэвтэрдэг тоос нь хэмжилт хийсэн Эрдэнэ сумын Байгаль хамгааллын улсын байцаагчийн ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байна. Аммиак тодорхойлсон усны лабораторийн ажлын байранд зөвшөөрөгдөх хэмжээнд үнэлэгдсэн.
- Бүх биеийн яс булчингийн эмгэгт өртөх эргономикийн үнэлгээний хуудсаар үнэлсэн Байгалийн нөөцийн бодлого хэрэгжилтийн газрын ажлын байрууд дунд эрсдэлтэй үнэлэгджээ. Ажилтай холбоотой ядралтын зэрэг үнэлсэн ажлын байрууд эрсдэлгүй үнэлэгдэж байна.

Хууль, стандартын хэрэгжилтийн үнэлгээний ерөнхий дүн:

БОУАӨЯам нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.2, 27.3, 28.1.7, мөн Эрүүл ахуйн тухай хуулийн 13.1.9, 13.1.10 болон бусад холбогдох хууль, дүрэм, тушаалын хэрэгжилтийг хангалтгүй ханган ажиллаж байгаа нь үнэлгээнээс харагдаж байна. Үүнд:

Хэрэгжээгүй буюу хангалтгүй хэрэгжсэн арга хэмжээ:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл, холбогдох мэргэжилтэнг томилон ажиллуулаагүй.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого хэрэгждэггүй
- Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн эрсдэлийн үнэлгээ, хэмжилт, хяналт-шинжилгээг дотооддоо тогтмол хийж хэрэгжүүлээгүй.
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт, инженерийн болон зохион байгуулалтын шийдлүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй.

Ажлын орчин нөхцөлийн хувьд:

- Ерөнхий агааржуулалтын систем байхгүй байна. Лабораторийн татах шүүгээний хэсгийн татах агааржуулалт хангалтгүй;
- Лабораторийн ажлын байруудын гэрэлтүүлэг стандарт хэмжээнд хүрэхгүй ;

- Лабораторийн хэрэглэж байгаа химийн бодисуудыг хадгалах байр стандартын шаардлага хангахгүй;
- Бүх ажлын байруудын талбай нэг хүнд ноогдох 6м^2 буюу стандартын шаардлага хангахгүй;
- Байгаль орчны лабораторийн ажлын байрны татах шүүгээ стандартын шаардлага хангахгүй, бусад лабораторууд нь ажлын байрны эмх цэгц муу
- Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтнүүдийн сандал эргономикийн шаардлага хангахгүй
- Гидробиологийн лабораторийн ажлын байр зориулалтын бус стандартын шаардлага хангахгүй
- Мөнгөнморьт сумын ойн ангийн ажлын байр өвөлдөө хүйтэн, шалнаас зэвтэг гардаг, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл байхгүй, сум дундаар явах албаны унаа байхгүй
- Байгаль орчны лабораторид улсын хэмжээнд хэрэглэж байсан ашигдаггүй болон гэмтэлтэй, хагарсан, цуурсан мөнгөн уст термометр 240 гаруй ширхэг байна. Зориулалтын бус газар хадгалаж байна.
- Мөнгөнморьт сумын Цаг уурын газарын барилга мөөгөнцөртэй, хүйтэн хана тааз цууралттай, багаж тоног төхөөрөмжийн хангамж, шинэчлэлт муу, цуурсан ашиглахаа больсон 10 ширхэг мөнгөн уст термометр хадгалалт зориулалтын бус байна.

Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, ажлын онцлогт тохирсон тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл:

- Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн хангамж муу
- Ажлын байрны анхан болон давтан зааварчилгаа өгдөггүй
